

“ХҮҮХЭД НЭГ БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ- БАГШИЙН АРГА ЗҮЙ

СХД-ИЙН 12-Р СУРГУУЛЬ

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Ч.ПҮРЭВЖАРГАЛ

2013 ОН

Эрхэм зорилго

**Эх оронч, Өрсөлдөх чадвар өндөр,
бүтээлч Монгол хүнийг төлөвшүүлнэ**

Зорилт

**Сурагчдын төрөлх хэлээрээ
алдаагүй зөв бичих, ярих чадварыг
хөгжүүлэх**

Судалгааны сэдэв:

Ирээдүйдээ итгэлтэй, хүнийг хүндэтгэдэг хүүхэд

Өдөр тутмын амьдралд байдаг, анзаарч байгаагүй зүйлүүдийг байгалийн ухааны хичээл дээр туршиж, биеэр хийж үзэх боломжийг бүрдүүлэх

Сэдэв сонгосон шалтгаан:

Сурагчдын өмнөх мэдлэгийн төсөөлөлд үндэслэх, өөрсдийн бүтээсэн бүтээлийг туршилтад хэрэглэх, **тайлбарлах чадварыг дээшлүүлэх**

Хичээлийн судалгааны зорилго:

Сурагчдын суралцахуйг дэмжих арга зүйг бодит хичээлээр дамжуулан суралцагчдын бие даан суралцах чадварыг илрүүлэн хөгжүүлнэ.

- Хичээлийн сэдэв:
“Хөдөлгөөний тоо хэмжээ”
Физикийн баг 10
гишүүнтэй,
96 анги, 30 сурагчтай
физикийн багш
С.Будлхам



Багийн гишүүд



- Технологийн багш М.Нармөнх
- Технологийн багш Д.Наранцэцэг
- Физикийн багш Г.Цэрэнханд
- Физикийн багш Г. Дөлгөөн-Ундрал
- Физикийн багш С.Будлхам
- Англи хэлний багш Ч. Энхжаргал
- Монгол хэлний багш Б.Энхболор
- Орос хэлний багш Б. Базар
- Биеийн тамирын Д.Олонбаяр

Сурагчдын судалгаа



Сурагчдаас гарч болзошгүй ташаа төсөөлөл, хариу үйлдлийн судалгааг хийхдээ дараах зүйлүүдийг чухалчлан анхаарсан.

Үүнд:

- Сурагчдын өмнөх ахуйн төсөөллийг судалсан
- Багш хичээлийн явцад сурагчдаас асуух асуултынхаа шинжлэх ухааны үндсийг нягталсан, оновчтой асуулт асуух
- Хүүхдээс гарч болзошгүй хариултыг судалсан.
- Тухайн ангийн ерөнхий төлөвшлийн судласан.

Агуулгын судалгаа



- Физикийн багаараа хамтран тэр дундаа мэргэжлийн багш нар Г.Цэрэнханд, Б.Дөлгөөн-Ундрал, С.Будлхам нар хамтран агуулгын судалгааг хийсэн.
- Тухайн хичээлийн стандарт дахь агуулгыг судалсан.
- 8, 9-р ангийн хөтөлбөр зөвлөмжийг харьцуулан судалж анги хоорондын агуулгын залгамж холбоог гаргаж ирсэн.
- Стандарт болон үндэсний хөтөлбөр зөвлөмж дээрх агуулга, сурах бичиг дээрх агуулгыг харьцуулан судалж хичээлийн ерөнхий агуулгыг гаргаж ирсэн.
- Хөдөлгөөний тоо хэмжээ хичээлийг амьдралтай холбож ахуйн төсөөллөөс нь шинжлэх ухааны хэл рүү оруулахыг оролдсон судалгааг хийсэн.

Арга зүй



- **Арга зүй:** Туршилтаар мэдлэг бүтээх аргазүйгээр хөдөлгөөний тоо хэмжээ гэсэн ухагдахууныг таниулах явцдаа асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, харилцан ярилцах аргуудыг хослон хэрэглэж, сурагчдын бүтээлч үйл ажиллагаан дээр тулгуурлан хичээл явагдана .
- **Хэрэглэгдэхүүн:** 500 гр ба 1000 гр масстай туухай, дүдү машины уралдааны зам /налуу зам/ 4 ш, 8 ш дүдү машин /массаараа ялгаатай/, см хуваартай шугам 8 ш, бичгийн цаас, тавган жинлүүр , LCD дэлгэц, проектор, компьютер, хугацаа хэмжигч
- **Хичээл зохион байгуулалт:** Нэг баг 6 гишүүнтэй нийт 4 баг багийн зохион байгуулалтаар ажиллана.

Сурагчийн ажлын хуудас

Хичээлийн сэдэв..... анги..... Сурагчийн нэр

2012-10-11

•Үзүүлэх туршилтын үр дүнг тайлбарлах

• Туршилт 1-ээс хүснэгтийг бөглөнө үү.

Хоёр машин хоёулаа хөдөлгөөн хийсэн

Машины масс байх тусам модон хаалтыг..... үйлчлэл байна

Машины масс байх тусам модон хаалтыг үйлчлэл байна

Модыг мөргөх машины үйлчлэл хаааарч байна

Модон хаалтын шилжисэн мөргөлтын үйлчлэлээс хамаарч байна.

•Туршилт 2 А, Б -ээс хүснэгтийг бөглөж гүйцээнэ үү?

• Машин хөдөлгөөн хийж байна

Налуугийн өндөр байх тусам машин 1 – ын байна.

Налуугийн өндөр байхад, машин 1 – ын байна.

Модыг мөргөх машины үйлчлэл хамаарч байна.

Модон хаалтын шилжисэн мөргөлтын үйлчлэлээс хамаарч байна.

•Дээрх туршилтуудаа нэгтгэн дүгнэнэ үү.

•Хөдөлгөөний тоо хэмжээний нь хүчийг мөргөлдөөн явагдсанүржсэнтэй тэнцүү

Бие	Налуугийн өндөр /см/	Модны шилжилт /см
Машин 1		
Машин 1		

Хичээлийн судалгаа хэрэгжсэнээр

Манай сургууль дээр 8
мэргэжлийн 8 баг тус
бүр 10-11 хүний
бүрэлдэхүүнтэй
хичээлийн судалгааг
зохион байгуулж
байна. Төсөл
хэрэгжснээр сурагчид,
багш нарт ямар
өөрчлөлт гарсаныг
судалгаа хийж нэгтгэв.



Хүүхдийн үйл ажиллагаа

- Хичээлд оролцох хүүхэд бүрийн идэвх нэмэгдэж байгаа
- Багаар ажилласан үед багийн гишүүн бүр ажил үүргийн хуваарьтай юу хийхээ мэддэг
- Сурагчид өөрсдийн мэдлэгийг үнэлүүлэхийг зорьдог болсон.
- Өөрийн гэсэн бүтээл хийх гэж оролддог
- Өөрийгөө голохгүй бусдын адил гэдгээ мэдэрч, шинжлэх ухааны нэр томьёо хэллэгийг чээжлэж, багшаас үнэлгээ авах гэж мэрийдэг болсон
- Туршилт, график, диаграмм, бодолтыг хийхийн өмнө сайтар ажиглан, заавартай танилцан, дарааллын дагуу цаг хугацаанд нь хийж гүйцэтгэхэд суралцаж байна.

Багшийн үйл ажиллагаа:

- Багууд байнга хамтарч ажиллан бие биенээсээ арга зүйн туршлага солилцон ажлын байран дээрээ хөгжиж, баг бүр өөрийн гэсэн онцлогтой, ажил үүргийн хуваарь хийж хэвшсэн.
- Ижил мэргэжлийн багш нар хичээл заах ангийн сурагчдын хурд, өмнөх мэдлэгийн төсөөлөл, хичээлийн агуулга, цаг төлөвлөлт, мэргэжлийн онцлогийг харгалзан туршилтыг сонгож, сурагчдаар эрэл хайгуул, судалгааг хийлгэн заавал бага ч гэсэн ахиц гаргахыг зорьдог
- Шинжлэх ухааны үг хэллэг хэрэглэх, амьдрал дээр хэрэг болох мэдээлэл, туршилт, жишээ баримтыг сонгох
- Сурагчдын судалгаанд анхаарч тэднээс ирж болзошгүй асуултыг тооцох
- Хүүхдүүдийг будилуулахгүй оновчтой асуултыг бэлтгэх, системтэй, дүгнэлтийг өөрсдөөр нь гаргуулахад чиглүүлж, бүтээлч гэрийн даалгавар өгөх
- Ямарч хичээлийг хүүхдийн байр сууринаас төлөвлөж, бүтээл гаргахад анхаарах
- Хичээл хоорондын залгамж холбоог уялдуулах, учирч болзошгүй бэрхшээлийг тооцох
- Туршилтын хэрэглэгдэхүүнийг аль болох гарын доорх материалаар хийх
- Техникийн сааталыг тооцох

Сайн тал:

- Харилцан зөвлөлдөж хичээлээ төлөвлөн судалгааг хуваарилан хийдэг.
- Багшийн заах арга зүйд өөрлөлт орж байгаа нь багш бүрт мэдрэгдсэн.
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх гэж хичээдэг
- Хичээлд дүгнэлт хийлгэх, сурагчдыг үнэлэх шинэ шинэ аргуудыг сурсан.
- Хүүхдүүд өөртөө итгэх итгэл нэмэгдэж, хичээлд оролцох оролцоо сайжирсан.
- Багийн өөр мэргэжлийн багш нараас хичээлийн туршилт болон сэдэлжүүлэлтийг сонирхолтой болгох шинэ санаа их гарч ирдэг.
- Эцэг эхийн оролцоо нэмэгдсэн.

Сул тал:


- Ижил мэргэжлийн багш нар олон байх тусмаа алдааг оновчтой олж харж засан сайжруулах зүйлийг нарийн гаргаж илрүүлдэг. Ижил мэргэжлийн багш нар цөөн бол мэргэжлийн алдааг оновчтой харж чадахгүй байх талтай.
- Өөр мэргэжлийн багш нараас арга зүйн туршлага судлах сайн талтай ч мэргэжлийн зөвлөгөө дутагддаг мөн эдийн засгийн бэрхшээл тулгардаг.

3 жилийн хугацаанд судалгаат хичээл зааснаар дараах үр дүнд хүрсэн

- Ээлжит хичээлийг чанартай бэлтгэхэд анхаардаг.
- Бусад багш нарын туршлагаас судалдаг.
- Ажиглах арга зүй сайжирсан, юуг яах гэж ажиглаж байгаагаа ойлгосон.
- Хэлэлцүүлэг хийн засан сайжруулах алдаагаа олж, засан сайжруулж заах эсвэл хөтөлбөрөө сайжруулдаг.
- Хичээлийн судалгааг тасралтгүй явуулснаар сургалтын үйл ажиллагаа жигдэрч, сургалтын чанар үр нөлөө сайжирч, багш нарын ур чадвар нэмэгдэн дүүрэг, нийслэлд жил бүр тогтмол 2-3 багш 1-р байр эзэлж байна.
- “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” сургалтын арга зүйг шинэчлэх төслийн БШУЯ-ны лаборатори сургууль болж сурагчдын авьяасыг хичээлээр илрүүлж хөгжүүлэн ажиллаж байна.

Япон улсын туршлагаас хэрэгжүүлж буй ажлуудаас

- Багш бүр удирдагч байдаг учраас тэнхимийн эрхлэгч, заах аргын нэгдлийн ахлагч нарыг 1-2 жилийн хугацаатай ээлжлэн ажлуулж байна.
- Бага ангийн сурагчид хичээл эхлэхийн өмнө 20 минут ном уншиж хэвшсэн.
- Ангиуд гэрээт үйлчлэгчгүй, сурагчид өөрсдөө ангиа цэвэрлэдэг.
- Үдийн хоолыг жижүүр сурагчид тарааж өгдөг.



Анхаарал тавьсанд
баярлалаа